

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “ХААН” банктай байгуулсан зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудын “ХААН” банктай 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан ЗЭНГ24/39 тоот зээлийн эрх нээх гэрээний зээлийн эрхийн хэмжээг 14,000,000,000 /арван дөрвөн тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн 97,000,000,000 /ерөн долоон тэрбум/ төгрөг болгон Зээлийн эрх /Олон зориулалттай зээлийн эрх/ нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, барьцааны нэмэлт гэрээ, холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Говь ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



(Handwritten signatures of the board members)

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ